

“ХӨНГӨН БЕТОН” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 02 дугаар сарын 18-ны өдөр

№ 01

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилахгүй тухай

“Компанийн тухай хууль”-ийн 46.1 дүгээр зүйл, “Хөнгөн бетон” ХК болон “Хас банк” ХХК-ийн хооронд 2012 оны 11-р сард байгуулагдсан “Хугацаат зээлийн гэрээ”-ний “Зээлдэгч нь аливаа ногдол ашиг зарлахгүй, олгохгүй” тухай “Хавсралт 3 В.1” дүгээр заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Хөнгөн бетон” ХК нь 2021 онд алдагдалтай ажилласан ба банкны өмнө хүлээсэн үүргийн дагуу ногдол ашиг хуваарилахгүйгээр шийдвэрлэсүгэй.
2. Хувьцаа эзэмшигчдэд “2021 оны ногдол ашиг хуваарилахгүй тухай” мэдэгдэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Н.Бүрэнжаргалд үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Б.Наранзул
Б.НАРАНЗУЛ

“ХӨНГӨН БЕТОН” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 02 дугаар сарын 18-ны өдөр

№ 02

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг
зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59, 60, 61, 62, 64, 65, 67 дугаар зүйлүүд, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 377 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Хөнгөн бетон” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2022 оны 3 дүгээр сарын 31-ны өдрийн 10.00 цагт Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Эв нэгдлийн гудамж-19/1, өөрийн байранд зарлан хуралдуулсугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг Нэгдүгээр хавсралтаар, хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчид мэдэгдэх өдөр, журам, бүртгэлийн өдөр, хуралд бэлтгэх явцад хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг Хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг удирдах хурлын даргаар Б.Наранзулыг томилсугай.

4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссыг дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Дарга
Гишүүд



Н.Бүрэнжаргал
Б.Болормаа
Г.Алтантуяа

5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай шийдвэрийг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн биржид хүргүүлэх, хурлын зар мэдээг Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”-д заасны дагуу хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх арга хэмжээ авахыг Гүйцэтгэх захиралд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б.НАРАНЗУЛ

ТУЗ-ийн 2022 оны 02-р сарын 18-ны өдрийн
02 тоот тогтоолын Хавсралт- 1



“Хөнгөн бетон” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн
2022 оны ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт

№	Хэлэлцэх асуудал	Танилцуулах хүн	Хугацаа
1	Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи дүгнэлтийг хэлэлцэж батлах	Б.Наранзул	30 мин
2	Ногдол ашиг хуваарилахгүй талаар танилцуулах	Б.Наранзул	5 мин
3	“Хөнгөн бетон” ХК-г “ХХК” болгон хэлбэр өөрчлөх талаар хэлэлцэх	Б.Наранзул	30 мин



ТУЗ-ийн 2022 оны 02-р сарын 18-ны өдрийн
02 тоот тогтоолын Хавсралт- 2

**“Хөнгөн бетон” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн
2022 оны ээлжит хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчид мэдэгдэх өдөр, журам,
бүртгэлийн өдөр, хуралд бэлтгэх явцад хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт
бичгийн жагсаалт**

1. “Хөнгөн бетон” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны ээлжит хурал хуралдуулах зарыг Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн 377 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”-д заасны дагуу хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэнэ.

2. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг ээлжит хурал хуралдуулах зарыг нийтэд мэдээлсэн өдрөөс хойш 15 дахь өдөр буюу 2022 оны 03 дугаар сарын 09-ны өдөр байна.

3. Хувьцаа эзэмшигчид нь ээлжит хурлыг зарласан үед дараахь баримт бичигтэй танилцаж болно. Үүнд:

1. Компанийн 2021 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан
2. Компанийн хэлбэр өөрчлөх тухай (ХХК)

--ooOoo--

**“ХӨНГӨН БЕТОН” ХК-ийн ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
АНХААРАЛД**

Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг **2022 оны 03-р сарын 31**–ний өдрийн **10⁰⁰** цагт өөрийн байранд хийнэ.

Хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи дүгнэлтийг хэлэлцэж батлах
2. Ногдол ашиг хуваарилахгүй талаар танилцуулах
3. “Хөнгөн бетон”ХК-г хязгаарлагдмал хариуцлагатай компани (ХХК) болгон хэлбэр өөрчлөх талаар хэлэлцэх

Бүртгэлийг тасалбар болгох өдөр: 2022 оны 03 дугаар сарын 11.

Хурлын материалтай 02-р сарын 25-наас 03-р сарын 11-ны ажлын өдрүүдэд 13⁰⁰-17⁰⁰ цагт компанийн байранд танилцаж болно.

Харилцах утас: 99288333

Хаяг: ХУД 3-р хороо, Үйлдвэр /17061/ Эв нэгдлийн гудамж 19/1.

E-mail: **masha20180101@gmail.com**

“ХӨНГӨН БЕТОН” ХК
Хурал зохион байгуулах комисс

“ХӨНГӨН БЕТОН” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 02 дугаар сарын 18-ны өдөр № 03

Улаанбаатар хот

Саналын хуудасны
загвар батлах тухай

“Компанийн тухай хууль”-ийн 71.3 дугаар зүйлийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Хөнгөн бетон”ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны ээлжит хурлаар шийдвэрлэх асуудлаар өгөх “Саналын хуудасны загвар”-ыг “Хавсралт №1”-ээр баталсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б. Наранзул

Б.НАРАНЗУЛ

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 02-р сарын 18-ны
өдрийн 03-р тогтоолын “Хавсралт-1”



**“ХӨНГӨН БЕТОН” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН 2022 ОНЫ
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН САНАЛЫН ХУУДАС**

Компанийн оноосон нэр: “Хөнгөн Бетон” Хувьцаат Компани

Хурал хуралдах газар, өдөр цаг : ХУД, 3-р хороо, Эв-Нэгдлийн гудамж-19/1,
“Хөнгөн бетон” ХК-ийн оффисын байр, 2022 оны 03-р сарын 31-ны 10:00 цаг

Хувьцаа эзэмшигчийн овог.....нэр.....

Хувьцааны төрөл: Энгийн

Эзэмшдэг хувьцааны тоо.....

Шийдвэрлэх асуудал ба санал өгөх хэлбэр

Д/ д	Шийдвэрлэх асуудал	Санал өгөх хэлбэр/ сонгосон саналыг + тэмдэгээр тэмдэглэнэ.		
		Зөвшөөрсөн	Татгалзсан	Түтгэлзсэн
1	Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи дүгнэлтийг хэлэлцэж батлах			
2	Ногдол ашиг хуваарилахгүй талаар танилцуулах			
3	“Хөнгөн Бетон” ХК-г “ХХК” болгож хэлбэр өөрчлөх талаар хэлэлцэх			

Санал өгсөн Хувьцаа эзэмшигч...../...../

2022 оны 02-р сар 18-ны өдөр